



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/68

Шивээговь сум

Сэг зэм устгалын ажил зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ариун цэвэр халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Сэг зэм устгалын ажилд зарцуулагдах хөрөнгийг гаргаж, ажлыг чанартай зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

4. Ажлын хэсгийн гишүүдийг мэргэжил, арга зүй, удирдлага болон шаардагдах ариутгалын бодисоор хангах, ажлын явцын гүйцэтгэлд дотоодын хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан, ажил үйлчилгээний чанар, заавар журам, технологийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч /Ш.Буяннэмэх/-д, тайланг нэгтгэн сумын Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /С.Отгонбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121-447

Сумын Засаг даргын 2021 оны
04-р сарын 27-ний өдрийн
1168-р захирамжийн хавсралт



МАЛЫН СЭГ ЗЭМ УСТГАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч :

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд :

Ш.Буяннэмэх

(Мал эмнэлгийн Улсын байцаагч)

Д.Отгонбаатар

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн
технологи, үржил бүртгэл хариуцсан
мэргэжилтэн)

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

Д.Эрдэнэтулга

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, жижиг дунд
үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Г.Мөнхжаргал

(Жолооч)

М.Эрдэнэбаатар

(Хогны машины ачигч)